

## Covid-19

Өглөө босоод коронавирусийн тухай мэдээ хайдаг дадал бидэнд өөрийн эрхгүй нэгэнтээ суужээ. Өнөөдөр 5 дугаар сарын 4. Даваа гараг. Хаврын энэ нэгэн өглөөний зугуухан мандаж зөөлөн ээх наран ч олигтой мэдээ авчирсангүй. Дэлхий даяар 3 сая 503 533 халдвар тогтоогдож, 919 167 хүн эдгэрч, 247 306 амь тэнгэрт хальсан байна. Манай хувьд, 4 дүгээр сарын 30-нд Инчоны нислэгээр 281 зорчигч ирсэнээс нэг хүн, 5 дугаар сарын 3-нд Франкфуртын нислэгээр 274 хүн ирсэнээс нэг хүнд тус тус халдвар илэрч, коронавирусийн 40 дэх тохиолдол бүртгэгдээд байна. “Дотоодын халдваргүй” хэвээр бололтой.

Даяарыг хамарсан цар тахлын үүсэл гарлаас авахуулаад энэхүү гамшигтай хэрхэн тэмцэж, хэзээ ялах хүртэл дэндүү өргөн асуудлаар даан ч хазааргүй маргаан хааяагүй өрнөж байна. Тэр их маргаан дундаас нэг л юм гэмгүйхэн тодорч байна гэлтэй. Аливаа асуудлын эрэмбэ эрс өөрчлөгдөх болно гэнээ.

Титэмтийн тухай мэдээ хайдаг дадлаасаа бид хэзээ салах бол оо?

Х.Б.

\* \* \*

- “We do not have government by the majority.  
We have government by the majority who participate.”  
Thomas Jefferson
- “The ballot is stronger than the bullet.”  
Abraham Lincoln
- “Voting is as much an emotional act as it is an intellectual one.”  
Monica Crowley
- “Not voting is not a protest. It is a surrender.”  
Keith Ellison



**Ж.Бор**  
Доктор, профессор

# ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ГАДААД БОДЛОГО

Монгол улс 1990-ээд оноос бий болсон дотоод, гадаад шинэ нөхцөл, Үндэсний аюулгүй байдлаа бие даан шийдвэрлэх шаардлагатай уялдуулан үзэл баримтлалын шинж чанартай гурван чухал баримт бичгийг боловсруулан гаргасан. Монгол улсын “*Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал*”-д үндэсний аюулгүй байдлын бүтцийг есөн үндсэн хэсэгт хуваан авч үзэж, түүнд нөлөөлөх хүчин зүйлүүд, аюулгүй байдлыг хангах арга зам, баталгааны талаар нарийвчлан зааж, тодорхойлсон бол “*Цэргийн номлол*”-доо *нэгд*, “*зөвхөн гадны зэвсэгт түрэмгийлээс өөрийгөө хамгаалах нөхцлийг бүрдүүлэх*, *хоёрт*, *өөрийн хүчээр няцаах боломжгүй түрэмгийлэлд өртвөл НҮБ-ын дүрмийн дагуу өөрийгөө хамтын хүчээр батлан хамгаалах*” арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар заасан байна. Харин “*Гадаад бодлогын үзэл баримтлал*”-д үндэсний аюулгүй байдлыг улс төр, дипломатын аргаар хангах нөхцлийг бүрдүүлэх гэж гадаад бодлогын гүйцэтгэх үүргийг зааж өгсөн билээ.

Үндэсний аюулгүй байдал гэдэг ойлголт нь сонгодог утгаараа гадны халдлага түрэмгийлэл, дотоодын бослого тэмцлээс тодорхой хэмжээгээр найдвартай хамгаалагдсан байдлыг хэлдэг. Гэвч өнөөдөр энэ ойлголт агуулгын хувьд ч, цар хүрээ, орон зайны хувьд ч өөрчлөгдөж, маш өргөн хүрээг хамардаг асуудал болоод байна. Тухайлбал НҮБ-

аас улс орны үндэсний аюулгүй байдалд шууд нөлөөлж болох 6 төрлийн аюулыг нэрлэн зааж, эдгээр аюул ойрын үед ч, алс хэддээ ч тулгамдсаар байх учраас улс орнууд үндэсний аюулгүй байдлынхаа хүрээнд онцгой анхаарвал зохино хэмээсэн. Тэдгээр цохон тэмдэглэсэн аюулууд нь:

*Нэгд*, хүрээлэн буй орчны доройтол, халдварт өвчин, ядуурал нүүрэлсэн нийгэм, эдийн засгийн аюул,

*Хоёрт*, улс хоорондын зөрчилдөөн, мөргөлдөөн,

*Гуравт*, иргэний дайн нүүрлэсэн улс орны доторх зөрчилдөөн, хүн төрөлхтөний эсрэг үйлдэж буй бусад томоохон гэмт хэргүүд,

*Дөрөвт*, цөм, хими, биологийн зэвсгийн аюул,

*Тавд*, терроризм,

*Зургаад*, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг ажээ.

Шинжлэх ухаан, техник, технологийн эрчимтэй хөгжил, эдийн засаг, соёлын даяаршил, байгаль орчны хямрал зэрэг нь аюулгүй байдлын тухай уламжлалт ойлголтыг ингэж эвдэж байна.

Тэгэхлээр бид үндэснийхээ аюулгүй байдлыг урьдын адил хаагдмалдуу явцуу хүрээнд бус өргөн утгаар цогц авч үзэж, түүнийг

улс төр, дипломатын аргаар хэрхэн хангах вэ гэдэг асуудлыг өндөр түвшинд алсын хараатай тодорхойлох шаардлагатай байна. Үүнээс үүдэн Монгол улсын үндэсний аюулгүй байдал өнөөдөр ямар байдалтай байна вэ гэдэг асуудал зүй ёсоор босож ирж байгаа билээ.

Юуны өмнө хэлэхэд төрийн хар хайрцагны бодлого аль эрт алдагдаж, манай гадаад, дотоод бодлого алсын хараагүй, харлаган шинж чанартай болсон байна. Үүний харгайгаар төрийн байгууллагуудын үйл ажиллагааны чанар чансаа алдагдаж, хариуцлагагүй, дэг журамгүй байдал хавтгайрч, авилгалд идэгдсэн төрийн доройтол үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байна. Монголын төрийн доройтлоос шууд шалтгаалан улс оронд бий болсон эдийн засаг, нийгэмийн өнөөгийн хямралт байдал үүнийг тодоос тод илчлэн харуулж байгааг үгүйсгэж хэн ч чадахгүй биз ээ. Ний нуугүй шуудхан хэлэхэд үндэсний аюулгүй байдал алдагдах аюул манайд ойрхон нүүрлэн ирсэн байна.

Эдийн засгийн аюулгүй байдалд нөлөөлж болох гадаад хүчин зүйл бас бий. Тухайлбал бусад орны түүхий эдийн хавсарга болох, эдийн засгийн стратегийн ач холбогдол бүхий салбарт бусад улсаас хараат байдалд орж байгаа нь Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон үндсэн асуудал болж байна.

Төрийн өндөр албан тушаалд шинээр томилогдсон хүмүүс гадаад бодлогын талаар мэдлэг, ойлголт дэндүү муутайгаас гадаад бодлого, дипломат бодлого хоёрыг ялгаж салгаж чадахгүй зах замбраагүй хутган холж, гадаад бодлогын залгамж болон нэгдмэл шинж чанарыг алдагдуулах зүйлийг болгоомжгүй, бодлогогүй хийж, Монголын гадаад бодлогыг зарчим муутай, алсын хараагүй, туйлбаргүй, ойлгомжгүй болгосоор байна. Үүний жишээ нь Монголд бие даасан шинжтэй дөрвөн гадаад бодлого буюу “*ерөнхийлөгчийн гадаад бодлого*”, “*ерөнхий сайдын гадаад бодлого*”, “*их хурлын гадаад бодлого*”, “*гадаад яамны гадаад бодлого*” оршин тогтнож байгаа сонин гаж явдал юм.

Гадаад бодлогын нэгдмэл болон залгамж шинж чанар үгүй болсон явдал үндэсний аюулгүй байдлыг улс төр, дипломатын аргаар идэвхитэй хамгаалахад тодорхой хэмжээний хүндрэл бэрхшээл авчирч байгааг илэн далангүй хэлэх цаг ч өнөөдөр болсон бололтой.

Дэлхийн их бодлого Монголд хэрэгжиж ирсэн геополитикийн уламжлалаас харахад олон улсын харилцаанд хоёрдугаар зэргийн шинж чанартай Орос, Хятад зэрэг улсууд Монголоор оролдож байх нөхцөл байдлыг бий болгож өгсөн ажээ. Энэ хөөрхийлөлтэй гэмээр нөхцөлд бидний дэвшүүлээд байгаа “*олон тулгуурт бодлого*”, “*хоёр хөршийнхөө дунд төвийг сахих бодлого*” маань зөв үү? Бидний өмнө босож ирээд буй аварга том зорилгод хүрэхэд энэ маань зөв зүйтэй хэрэгсэл болж чадах уу? Монгол улс гадаад бодлогын хувьд *raison d'etat* зарчим буюу хүчний тэнцвэр хадгалах зарчмын хүрээнд

хамрагдан орохыг хүсэж байсан боловч харамсалтай нь *realpolitik* буюу их гүрний ааглах бодлогын төмөр бахинд хавчигдсан байдгийг хэзээ ч мартаж болохгүй. Манай үндэсний аюулгүй байдалд шууд заналхийлсэн аюул ирэх л юм бол зөвхөн хоёр хөршөөс маань л ирнэ. Тиймээс бид болгоомжлох ёстой л юм бол хоеулангаас нь болгоомжлох ёстой.

Гэвч 1990-ээд онд Дорнод Европ, Азид ардчиллын үзэл санаа нэвтэрч ирснээр Монголчууд геополитикийнхоо таагүй байдлыг зөөллөх зорилгоор “*олон тулгуурт бодлого*” баримтлан явуулахаа зарласан билээ. Байдлаас харахад энэ нь стратегийн зорилт мэт харагддаг. Гэвч стратеги, номлол ба итгэл үнэмшил хоёрын хоорондын нууц зөрчиллийг хэрхэн гаргах, эс бөгөөс геополитикийн бодит нөхцөл байдал болон боломж бололцоо хоёрын хооронд хэрхэн сонголт хийхийг тооцож хэлж өгсөнгүй. Өөрөөр хэлбэл *raison d'etat*-ын хувьд харьцангуй шинэлэг зүйл биш боловч *realpolitik*-ийн хувьд шинэлэг зүйлийг Монголчуудын өмнө босгож ирэхдээ тэр бодлого бидний боломжид тохирох эсэх, Монгол орны геополитикийн нөхцөл байдалтай зөрчилдөх эсэхийг бидэнд сайтар ойлгуулж өгсөнгүй. Тэгэхлээр “*олон тулгуурт бодлого*” гэдэг маань *realpolitik*-ийн хувьд шинэлэг зүйл учраас энэ бодлогыг мөрдөхөө гунхаглан зарласнаас хойш Монголчууд бид нэг их гүрний бодлогыг зуун хувь аялдан дагалдахаа больсон. Харин “*олон тулгуурт бодлого*” нь *raison d'etat*-ын хувьд харьцангуй шинэлэг зүйл буюу тухайлбал Монголын хувьд геополитикийн таагүй нөхцлийг арилгаж, гадаад орчны хүчний харьцааг тэнцвэржүүлэх гэсэн зорилгоороо шинэ зүйл биш гэлтэй. Өөрөөр хэлбэл 1911 онд мэндэлсэн

“*гуравдагч хүчний бодлого*”-той энэ талаараа утга төстэй юм.

Манай геополитикийн орчинд XVII зууны ба XX зууны геополитикийн орчинтой нь харьцуулбал тодорхой өөрчлөлт орж, шинэ шинэ хүчин зүйлүүд бий болж буйг үгүйсгэх араггүй. Өөрөөр хэлбэл манай геополитикийн нөхцөл байдлын буруутан болсон хоёр хөрш маань *нэгд*, ардчилагдаж байна, *хоёрт*, даяарших үйл явцад улам хүчтэй татагдан орж байна. Манай геополитикийн орчинд орж ирсэн орчин цагийн олон улсын харилцааны эдгээр шинэлэг хүчин зүйл нь Монголын хувьд сайн, муу аль аль талтай байж болно. Тухайлбал хоёр хөрш маань ардчилагдах нь тэдний гадаад бодлогыг (Монголын талаарх бодлогыг) зөөлрүүлж, харьцангуй уян хатан шинж чанартай болгож байгаа ч тэдний зүгээс манайд ирэх геополитикийн даралт, дарамтыг бидний санасан шиг тийм хэмжээгээр багасгахгүй нь ойлгомжтой.

Оросын бодлого манай хувьд ямагт хоёрдмол шинжтэй, Хятадын бодлого Монголыг нэгтгэн авах хатуу чиг шугамтай байсан, байгааг бид мартаж ёсгүй. Тиймээс Орос, Хятад хоёрын бодлогын угийг сайтар шинжиж үзвэл тэдгээр бодлогод чанарын гүн гүнзгий өөрчлөлт гарах яагаа ч үгүй байна гэж хэлж болохоор юм. Энэ бол Орос, Хятадын харилцаанд *raison d'etat* зарчим нэвтрэхэд ахиц гараагүйг харуулж буй шинж чанар бөгөөд энэ учир *realpolitik*-ийн зарчимтай тэдгээр улстай харилцах харилцаандаа төвийг сахих бодлого баримтлахад нэн төвөгтэй болохыг илэрхий болгож байна.

Энэ маань ч олон тулгуурт бодлого ба хоёр хөршийнхөө дунд төвийг сахих бодлогын аль

алиныг нь явуулж болохгүйг бараг нотлоод өгч байна. Өөрөөр хэлбэл энэ хоёр бодлогын эхнийх нь Монголын хувьд эерэг сөрөг урсгал шинж чанартай буюу бараг анархи шинжтэй, нөгөөх нь бодит бодлогоос ангид хэт идеалист шинж чанартай байна.

Улс орны удирдагч дөтлөн ирж буй аюулыг урьдчилан мэдрэх аваас суурь шинж чанартай гүн гүнзгий шийдвэр гаргах оролдлогыг заавал ч үгүй хийх ёстой. Гэтэл манай улсын төрийн болоод дипломатын шинж чанартай үйл ажиллагаа буюу хоёр хөрштэйгөө хамтарч ажиллахаар урьдаас төлөвлөсөн хийсвэр төлөвлөгөө, Японыг өөрөөсөө хөндийрүүлж хүйтрүүлэх ойлгомжгүй бодлого, АНУ болон Европын холбооны улсуудад эргэлзээ төрүүлэх байдал зэрэг нь нэгдэн нийлснээр манай гадаад бодлогын хувьд удаан тэсэж тогтохын аргагүй нөхцөл байдлыг өдгөө бий болгож магадгүй болчихоод байна. Ийм байдал гүнзгийрэх аваас манай гадаад бодлогын амин сүнс алдагдах төдийгүй олон улсын харилцааны явцад хийсэн өөрсдийнхөө задлан шинжилгээнд тулгуурлан үйл ажиллагаа явуулж чадахаа болиход хүрнэ. Үүнийг тойрч гарах арга чарга бидэнд бий юу?

Монголчууд бид хоёр зүйлийг нарийвчлан сэтгэж, ялгаж салган тус тусад нь гүн гүнзгий ойлгох ёстой. Өөрөөр хэлбэл өөр өөдөө дэлхийн анхаарлыг хүчтэй татах гэж оролдох нь бидэнд ашигтай юу, аль эсвэл өнөөгийн байдалдаа сэтгэл хангалуун үлдэх нь ашигтай юу гэдгийг нарийн тунгаах явдал нэн чухал болоод байна. Энэ хоёр замын алиныг сонгносноос хэрхэх вэ гэдэг хоёр тусдаа аргачлал гарч ирнэ. Хэрвээ бид эхний замыг сонговол доорх хүчин зүйлүүдийг тооцон

аргачлалаа боловсруулан гаргах ёстой.

*Нэгэн зүйл.* Дэлхий дахин манай улсыг бага анхаарч ахуйд тэдний анхаарлыг татахын тулд манайх шиг хоёрхон хөрштэй улс гуравдахь хүчийг ямар нэгэн байдлаар заавал ч үгүй оруулж ирэх шаардлагатай. Энэ нь хоёр хөршийнхөө бодлогыг зөөллөж өгөх төдийгүй геополитикийн хувьд ухаажуулах, анхаарлыг нь зөв чигтэй болгоход тустайгаар барахгүй дөрөвдөгч өөр бусад орнуудын бодлого орж ирж байх байнгын сувгийг нээлттэй болгож өгнө.

*Нэгэн зүйл.* Дэлхийн тэргүүн орны анхаарлыг өөр өөдөө байнга татаж байх үүднээс түүний эрх ашгийг бий болгох оролдлогыг байнга бөгөөд цуцалтгүй хэрэгжүүлэх шаардлага тулгарна.

*Нэгэн зүйл.* Дэлхий нийтийн амин чухал болон олон улсын харилцааны тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд өндөр идэвхи, чанга сонголонтой дуу хоолойтой байхыг хичээн оролдох явдал чухал юм.

Хэрвээ бид хоёрдох замыг сонговол мөн л доорх хүчин зүйлүүдийг тооцон аргачиллаа боловсруулан гаргах ёстой.

*Нэгэн зүйл.* Улс төрийн зүтгэлтэнүүд, гадаад бодлогын шийдвэр гаргагчид, дипломатууд, бүр цаашлаад хүн бүхэн Монголынхоо төдийгүй Евразийн дипломатын түүхээ гүн гүнзгий мэддэг байх зайлшгүй шаардлагатай. “Түүхээсээ сургамж аваагүй ард түмний мөхөл нь ирдэг” гэсэн бичигдээгүй хууль бий учраас Монголын унаж боссон түүхийг мэдэхийн учир энэ буюу. Үүнийг чухам төрийн бодлого болгон зангидваас зохилтой.

*Нэгэн зүйл.* Монголын дипломат бодлогыг гүн гүнзгий утга агуулгатай, мөн нэгдмэл ба залгамж шинж чанар төгс болгох нь унаж босохын алинд ч эндэж гундаагүй Монгол түмний тусгаар тогтнолыг мөнхлөхөд нэн тустайг эцсийн эцэст ухаарах нь зохиролтой. Энэ их үйлсийг улс төрийн давалгааныг эс ажиран барьж чадах цорын ганц хүчин нь эх оронч гүнзгий сэтгэхүйтэй хүмүүсийн бүлэг байдгийг хэзээ ч мартаггүй. Төрийн тусгаар тогтнолыг хамгаалах Монголын гадаад бодлого төрийн эрх авсан улс төрийн хүчний ухвар мөчид бодлогын харгайгаар баруун зүүн тийш холбирахгүйн учир энэ буюу.

*Нэгэн зүйл.* Хоёр хөрш маань ил далд олон зөрчилтэй ч Монголын асуудал дээр амархан зохицолддогийг санагалзан элдвийн интернационализм (пролетарийн болоод социалист), космополитизмээс зайлсхийж явах нь Монголчууд бидэнд өлзийтэй. Цөөн Монголыг уусгаж алга болгохгүйн учир энэ буюу.

*Нэгэн зүйл.* Хүндээ хөнгөнөөсөө өгөхгүйн тулд өнөөгийн Монголчуудын бараг онцлог нь болсон атаач, матаач, хэрүүлч, мушгааач зангаа орхицгоож, тусгаар тогтнолоороо амьсгалж, амьдарч түүнийхээ төлөө бүхнээ зориулах нь бидэнд нэн тустай. “Барын сүүл явснаас батганы толгой болж” эрх чөлөөтэй явахын гайхамшиг энэ буюу.

*Нэгэн зүйл.* Бүх нийтийн эх оронч халуун үзэл, тусгаар тогтнол, үүх түүхээ юунаас ч дээдлэх сэтгэлээ, улс төрийн тогтвортой байдлыг баттай хангах ба эдийн засгийн хувьд хүчирхэгжих эрмэлзэлтэй бүрэн хослуулж чадвал тавьсан зорилгодоо бид хүрч чадна.

# ГАДААД БОДЛОГЫН THINK TANK БАЙГУУЛЛАГА БИДЭНД ЯАГААД ХЭРЭГТЭЙ ВЭ?

Өдгөө манайд улс төрийн намууд төр, засгийн эрх мэдэл, үйл ажиллагаанд хэтэрхий оролцон нөлөөлдөг болсон, төрийн бүх шатны ажилтнуудын хуулийн ухамсар, ёсзүй дорой, хариуцлага хүлээх чадвар сул байгааг үл харгалзан тэднийг соён гэгээрүүлэх, эрдэмжүүлэх ажил явахаа больсон хүнд нөхцөл нүүрлээд удаж байна. Ийм хүнд нөхцөлд гадаад бодлого зөв өрнөх, “залгамж” болон “нэгдмэл” чанараа хадгалж байхад маш хүндрэлтэй болдог. Тухайлбал, ГХЯ-ны зүгээс нэгдсэн бодлогоор хангах, гадаад харилцааны үйл ажиллагаанд оролцогсдыг зангидан чиглүүлж удирдах, нэгдмэл зохицуулалтаар хангах явдлыг үлэмж хэмжээгээр сулруулдаг.

Төрийн гадаад бодлого, Засгийн газрын бодлого нь хямралд орсон үед *think tank*-чдын үзэл бодол ихээхэн нөлөө бүхий болдог бөгөөд *think tank* сэтгэлгээний нөлөөллийн нэг хүчин зүйл бол тэдний боловсруулсан улс төрийн өвөрмөц үзэл баримтлал юм. Түүхийн тодорхой үе шат нь гадаад бодлогын хүрээнд шинэ сэтгэлгээг нэвтрүүлэх таатай нөхцлийг бий болгодог.

*Think tank* судлаач гэдэг бол ерөөсөө шинжлэх ухааны хөшүүн аргачлалаар ажилладаг ердийн хүмүүс биш учраас их дээд сургууль төгсөж бэлтгэлтэй болсон гэгдэгч хэн хүний

хийчихдэг ердийн ажил биш юм. Тэд маш өвөрмөц буюу уламжлалт бус (стандартчилагдаагүй) арга барилаар ажилладаг, боловсруулж гаргасан баримт бичиг нь санаанд оромгүй өвөрмөц шийдэлтэй, амьдрал дээр хэрэгжиж, нөхцөл байдлыг эрс өөрчлөх өндөр магадлал, чадвартай байх ёстой. Тиймээс *think tank* байгууллага нь байгалиас заяасан оюуны өргөн царатай, загварчлагдаагүй сэтгэлгээтэй, аливаад нэвтэрхий харцтай, уужим дэлгэр мэдлэгтэй хүмүүсээс бүрдсэн байх ёстой байдаг. Эдгээрийн аль нэг дутваас тэр хүн *think tank*-чин яагаад ч болж чадахгүйн нэгэн адилаар *think tank* гэдэг нэрийг байгуулгынхаа нэрэнд оруулж зүүсэн төдийгөөр *think tank* байгууллага болчихдоггүй.

Чухам тиймээс *think tank*-чин хүн дээр дурьдсан дөрвөн чадавхдаа тулгуурлаад өөрөө өвөрмөцөөр хөгжсөөр бусдаас цоорч гарч ирдэг жамтай гэж хэлж болно. Ийм хэтийдсэн оюун, сэтгэлгээтэй хүмүүсийг нэгтгэж нийлүүлж чадсан байгууллага л *think tank* байгууллага болдог. Өөрөөр хэлбэл дурын судалгааны төв (ямар ч байгууллагын харьяалалтай байсан), эрдэм шинжилгээний хүрээлэн *think tank* байгууллага болох магадлал муутай гэдэг нь ойлгомжтой. Учир нь *нэгд*, тэд арга барилын хувьд ч, боловсон хүчний хувьд ч *think tank* байгууллагын зарчим, арга

барилаар ажиллаж чаддаггүй, бас ойлгодоггүй, ойлгосон ч учраа олдоггүй. Дундаж сэтгэлгээний нэг айхтар сул тал бол аливаа юмыг уг үндсээр нь ухаж ойлгож, дотоод мөн чанарт нь хүрч чаддаггүйд байдаг.

*Хоёрдугаарт*, тэдний сэтгэлгээ асар хүчтэй загварчлагдсан байдаг онцлогтой.

*Гуравдугаарт*, тэд нийгмийн хэмжигдэхүүнээр өндөр боловсролтой байж болох ч мэдлэг (боловсрол буюу мэдээллээ амьдралд хэрэглэх чадвар), эрдэм (мэдлэгээ хэрэглэх увьдас) муутай байдаг гэж хэлж болно. Жишээ нь манай дундаж сэтгэлгээтнүүд Гадаад бодлогын үзэл баримтлалыг шинэчлэх гэж оролдоод чадал нь хүрэлгүй нэг жижигхэн байгууллагад таарах, хоосон гоё үг хэлхсэн ажлын удирдамж төдий зүйл болгож хувиргасан. Өөрөөр хэлбэл тэд концептуальный буюу номлолын шинж чанартай баримт бичиг ямар хэлбэр, агуулгатай байх ёстойг ойлгох чадваргүйгээ ухааралгүй тэр ажлыг нэр төр хөөцөлдөх хэрэг болгож орхисон. Манай Гадаад бодлогын шинэ үзэл баримтлалыг уншиж үзсэн гадаадын мэргэжилтнүүд “үгүй энэ Монголчууд чинь үзэл баримтлалын (концептуальный) шинж чанартай баримт бичиг, ажлын удирдамж хоёрын ялгааг мэддэггүй юм байх даа” гэж гайхширдаг байх хэмээн надад үргэлж бодогдож, тэдний өмнөөс ичдэг гэдгийг энд хэлэх юун.

*Super* гэгдсэн нүсэр зузаан судалгааг судалгааны төв, эрдэм шинжилгээний хүрээлэн зэрэгт захиалаад хийлгэчихэж болдог. Гэвч дундаж сэтгэлгээтэй судлаачид шинжлэх ухааны хөшүүн арга барилтай, хэт загварчлагдсан сэтгэлгээтэй, нэвтэрхий харц дулимаг байдгаас *super* судалгаа нь гол төлөв амьдралд хэрэгжих чадвар тааруу байдаг.

Харин гадаад бодлогын практик алхам дээр хэрэглэж болохуйц өвөрмөц шийдэл бүхий баримт бичгийг боловсруулан гаргаж ирдэг *think tank*-чдийн тухайд бол огт өөр яриа явах ёстой. Тодруулах аваас *think tank*-чин хүн гадаад бодлогын хүрээнд өвөрмөц шийдэл гаргаж өгөх, өнөөгийн хүнд нөхцөл байдлаас гаргах гарц нээх, ирээдүйд бүрдэх нөхцөл байдлыг урьчилан мэдэрч дүн шинжилгээ өгөхийн зэрэгцээ түүнийг удирдан жолоодох өвөрмөц сэдэл, өвөрмөц аргачлалыг боловсруулах чадвартай байна гэсэн үг. Тэдний боловсруулсан үйл ажиллагааны саналтай танилцсан төрийн гурван өндөрлөг “*гадаад бодлого гэдэг чинь тийм амар хялбар зүйл биш юм байна*” гэж ухаарч болгоомж, ойлгоц, ухамсартай болох, эс бөгөөс мэргэшсэн мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар гардан хийгээд үзэхээр шийдэхэд хүргэнэ. Энэ нь гадаад бодлогын чухал шинж чанартай, ул суурьтайг ойлгуулж цочирдуулах, мөн тэрхүү өвөрмөц аргачлалыг хэрэгжүүлж нэр хүндээ өсгөх, эсбөгөөс түүнийг Гадаад яаманд хэрэгжүүлэхийг зөвшөөрөх сонирхолыг бий болгодог. Эдгээр хувилбарын алинаар нь ч шийдсэн улс оронд үр өгөөжөө өгнө.

*Think tank* үйл ажиллагааг сэтгэлгээний болон оюун ухааны хүчинд тулгуурлан

тухайн нөхцөл, цаг үед гаргаж болох зохистой, үндэслэлтэй, үр ашигтай шийдлийг боловсруулан гаргадаг “*оюуны инженерчлэл*” хэмээн ойлгож болох юм. “*Оюун сэтгэлгээний энэхүү үйлдвэрлэл*” нь нэгд, хорвоогийн хамгийн хүчирхэг хэрэгсэл болсон “*оюун ухаан*”-ыг хөгжүүлэх, түүнийг хэрэглэх талбарыг төрийн ноёрхлоос ангижруулж, оюун ухаан гол зэвсэг нь болсон бүхэл бүтэн нийхэмийн инженерчлэлийг бий болгох, шийдвэр гаргагчдын хувийн хариуцлагыг өндөржүүлэх, хариуцлагаа хүлээх чадвартай нам, улс төрийн хүчин төлөвших, тэднээс багийн тоглолт явуулж чаддаг улс төрийн чадвар өөд шилжих явцын илрэл юм.

*Think tank* байгууллага бол оюуны маш өвөрмөц арга барилаар ажилладаг хүмүүсийг нэгтгэсэн гоц байгууллага юм. “*Уламжлалт аргаар дайтаж, уламжлалт бус аргаар ялна*” гэдэг оюун ухааны дээд зарчим бол *think tank* сэтгэлгээ, үйл ажиллагааны туг болж байх ёстой. Өөрөөр хэлбэл “*уламжлалт бус аргаар давуу тал олж авна*” гэдэг томъёолол бол *think tank* сэтгэлгээний гол зарчим юм. Тиймийн тул өвөрмөц, гоц гойд арга, аргачлалыг тухайн нөхцөл байдал бүрд тохируулан гаргаж ирж хэрэглэнд оруулж байх явдал бол *think tank* байгууллагын үндсэн зорилго мөн.

*Think tank* үйл ажиллагаа нь гадаад улс төрийн үйл явцад дорх чиглэлээр оролцдог гэж хэлж болно. Үүнд:

- шинэ соргог үзэл санаа, бодлогын хувилбаруудыг боловсруулж гаргах,
- шинжээчдийн *think tank* багийг Засгийн газарт ажиллахад бэлдэх,
- тодорхой асуудлаар дээд

хэмжээнд хэлэлцүүлэг явуулах санал дэвшүүлэх,

- хүн амыг олон улсын харилцаа, гадаад бодлогын талаар гэгээрүүлэх ажил хийх,
- аливаа нэгэн зөрчил мөргөлдөөнийг зохицуулах, зуучлахад төрийн байгууллагад туслах гэх мэт.

*Think tank* байгууллага санал, шийдэл болон хөтөлбөр боловсруулан гаргаж, тэдгээрийг хэрэгжүүлэх арга, аргачлалаар хангаад зогсохгүй түүнийгээ шийдвэр гаргагчдын оюун санаанд нь суулгаж өгөх хэмжээнд ажилладаг байх ёстой. Өөрөөр хэлбэл *think tank* бүтээгдэхүүнээ хэрэглэгчдэд саадгүй шууд борлуулах, улс төрийн элитүүдэд үзэл баримтлалыг хүлээн авахуулах чадвар бүхий олон нийтийн саналыг боловсруулан хүргэж чаддаг байх ёстой болдог.

*Think tank* байгууллага нь улс төрийн шийдвэр боловсруулах үйл явцад оролцох боломжид хүрэх олон янзын албан ёсны сувгуудыг байнга ашигладаг. Тухайлбал УИХ-ын болон Засгийн газрын сонсгол дээр өөрсдийн шинжээчдийг оролцуулах, саналаа хэлэх гэх мэт. Нөгөөтэйгүүр *think tank*-чид нь албан бус хэлбэрээр ч шийдвэр гаргагчид болон бодлого боловсруулагчидтай холбогдож, тодорхой асуудлаар хамтран ажилладаг.

Нөгөөтэйгүүр *think tank*-чдын дүгнэлтийг шийдвэр гаргагчид хүлээн аваагүй нь асуудал дууссан гэсэн үг хараахан биш юм. Тэдэнд өөрсдийн үзэл сэдлээ олон нийтийн санаа бодолд хүргэж, тэднээр дамжуулан шийдвэр гаргагчдад шууд бусаар нөлөөлөх арга байдаг. Мөн өөрийн боловсруулсан үзэл, санал, хөтөлбөрийг шийдвэр

гаргагчдад зарж борлуулах арга ч бас бий. Түүнчлэнгээр *Think tank* байгууллага нь өөрийн ажлын үр дүнг хэвлэл-мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэн тарааж, тэдний дэмжлэгийг авч өөрийн байр суурь, санаа сэдлийг хамгаалж үнэ цэнэд хүргэх арга ч гэж бий.

*Think tank* байгууллагын шууд бусаар нөлөөлөх бас нэг аргачлал бол соён гэгээрүүлэх үйл ажиллагаа юм. Байгууллага шинжлэх ухаан, танин мэдэхүй, соён гэгээрүүлэх чиглэлийн судалгааны томоохон сэтгүүлтэй байж, орчин үеийн мэдээллийн технологийг өндөр хэмжээнд ашиглаж, үйл ажиллагаагаа таниулж, өөрийнхөө зах зээлээ нээж байх ёстой болдог. *Think tank* байгууллага нь мөн өөрийн сайттай байх зайлшгүй шаардлагатай. Түүнийгээр сар бүр шинэ мэдээллээр баяжуулж, мэдээлэлдээ тогтмол дүн шинжилгээ хийж, эрэлт хүлээлтийг нэмэгдүүлж байдаг учиртай.

Жишээ нь манай улсыг тойрч бүрэлдэн тогтсон гадаад орчинд өгсөн дүгнэлт, тодорхойлолтыг л авч үзэхэд огт буруу буюу билгийн ухааны нэвтэрхий харц дутсан байдал харагддаг. Тодруулах аваас алсын хараатай эрүүл ухаанаар арай гүнзгий харах юм бол орчин цагийн ертөнцийн хөгжил дэвшлийн боломжууд гаднаас манайд орж ирэх үүд хаалгыг манай хоёр хөрш багтай хааж авсныг эдийн засаг, улс төр, гадаад харилцааны салбарын олон зүйл дээр харж болохоор байдаг. Өөрөөр хэлбэл улс орны хөгжил дэвшилд түлхэц өгөх дэвшилтэт техник, технологи, цахим техник, үйлдвэрлэл нэвтрэн орж ирэх боломж хаалттай гэсэн үг юм. Манайд сүүлийн 30 жилд орж ирсэн технологи, цахим техник,

олзворлох үйлдвэрлэл зэрэг нь Монголоос ашиг, мөнгө хоёрыг гадгаш тууж гаргах боломжийг нээлттэй байлгаж, дэм үзүүлэх төдий зүйлс байдаг.

Ер нь их гүрнүүд хөгжил дэвшилд хүрэх үүд хаалгыг жижиг буурай орнуудын хувьд маш өчүүхэн завсартайгаар онгойлгосон байдгийг эрүүл ухаантай хүн бүхэн мэднэ гэж хэлж болох биз ээ. Харин манай хоёр хөрш тэр нарийхан онгорхой завсрын өмнүүр бас нэг үл ажиглагдам хаалт босгосныг өдгөө бид олж харах ёстой. Тэдний далд бодлогын цаад гүн гүнзгий учир нь Монгол дээш гарахаар хоёулаа доошоо ордог түүхэн туршлага дээрээ тулгуурласан уламжлалт үзэл баримтлалд нуугдаж байдаг билээ. Тийм ч учраас биднийг олон зууны туршид далай тэнгисээс тасалж, хуурай газрын гүн лүү шахсаар гурван талаараа өндөр уулсаар хүрээлэгдсэн, өмнө талаараа элсэн говиор хаагдсан газарт түгжиж авсан нь ийм далд нарийн учиртай.

Үнэндээ бол Монголчууд идэвхи санаачилгаар огт дутаагүй, харин тэдэнд орчин цагийн хөгжилд зайлшгүй чухал боломжуудыг ашиглах боломж өгөхгүй байгаад л хамаг учир нуугдаж байгаа юм.

Бидний хувьд хөгжил дэвшлийн орчин цагийн боломжууд гэдэг бол алсын юмыг ойрхон мэт харагдуулах зэрэглээ шиг зүйл юм. Тиймээс бид хөгжбэ гэвэл асар их өвөрмөц сэтгэлгээгээр олон саад бэрхшээлүүдийг давж гарч байж хөгжил дэвшилд хүрнэ. Юун түүрүүнд тэдэнтэй аргын ухаан уралдуулахаа больж, билгийн ухаанд шүтэх хэрэгтэй болох нь ойлгомжтой. Манай ухаант өвөг дээдэс дундад эртний үе буюу Их Монгол улсын үед аргын

ертөнцийн эсрэг билгийн ухаан хэрэглэж, өөрсдөөсөө олон арав дахин хүчтэй улс гүрнүүдийг ялж гарч байсныг бид хэрхэвч мартаж ёсгүй.

Эцэст нь хэлэхэд *think tank* байгууллагын ажлыг хэвлэл мэдээлэлтэй хэр зэрэг холбоотой, олон нийтэд хүрсэн нийтлэлүүд, тэдгээрээс нь судлаачид тогтмол ишлэл татсан байдал, орон тооны томоохон шинжээчид, судлаач-эрдэмтэдийн бүрэлдэхүүн, дэвшүүлсэн үзэл бодол нь телевиз, радио, интернетэд хэр их үзэгддэг, шийдвэр гаргагч түвшинд хэр танигдсан эсэх, хэр олон зөвлөмжийг төр засагт хүргэж байсан, байгууллагын санхүүгийн чадавх, шинэ санаа, шинэлэг мэдлэгийг шийдвэр гаргах үйл явцад хүргэх чадвар зэргээр<sup>1</sup> шийдвэр гаргагчид үнэлдэгийг анхаарч ажиллах ёстой.

*Think tank*-чид гоц гойд аргачлал, гадаад бодлогын өвөрмөц алхамуудыг тухай тухайн нөхцөл байдалд тохируулан боловсруулан гаргаж ирэхийн зэрэгцээ хойчийн *think tank*-чдаа ямагт эрж хайж байх ёстой. Тиймээс сэтгэлгээг цаг ямагт сэрүүн сэргэг байлгахын тулд гурван үеийн төлөөлөгчид хамтдаа байх нь чухал гэдэг нь ойлгомжтой. Ямар ч хүмүүс байлаа гэсэн бие биенээсээ суралцаж чадсан хүмүүс л хожиг гардаг.

<sup>1</sup>Donald E. Abelson. *A Capitol Idea. Think Tanks & US Foreign Policy.* McGill-Queens University Press, 2006, p.156



Л.Удвал

Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд

# МОНГОЛТОЙ ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТООСОН ТАВ ДАХЬ УЛС-ПОЛЬШ

Монгол, Польшийн хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ой энэ онд тохиож байна. Дэлхийн хоёрдугаар дайны дараахан манай улс ЗХУ-аас гадна БНАСАУ, Албани, БНХАУ-тай албан ёсны дипломат харилцаатай болоод байсан бөгөөд улмаар Европт социалист систем буй болж 1950 оны дөрөвдүгээр сарын 13-нд хуучин БНАГУ, 14-нд Польш, 22-нд Болгар, 28-нд Унгар, 29-нд Румын зэрэг орнууд дараалан БНМАУ-тай дипломат харилцаа тогтоосон юм. Эдгээр улсуудаас хуучин Зүүн Герман 1990 онд Баруунтайгаа нэгдэж ХБНГУ болсноор Польш улс “дэвшиж” манайтай дипломат харилцаа тогтоосон орнуудын “айргийн тав”-д багтах болсон түүхтэй.

Польш бол Монголтой түүхэн харилцааны эртний уламжлалтай орон гэж хэлж болох юм. Бүр 1240- өөд оны эхээр Ромын пап лам IV Иннокентийн зараалаар түүний захидлыг Гүюг хаанд хүргэж ирсэн өрнөдийн анхны элч Пано Карпинигийн хамт Их Монгол Улсын Их хааны орд өргөөнд хөл тавьсан анхны Европчуудын нэг нь католик шашны францискийн урсгалын төлөөлөгч, польшийн санваартан Бенедикт Полак байжээ. Тэрээр туршлагатай аялагч, газарзүй, латин, эртний орос хэл сайн мэддэг хүн байсан тул Пано Карпини түүнийг орчуулагчаар авч их аялалаа гүйцэлдүүлсэн гэдэг. Бенедикт Полак 1247 онд буцаж ирээд

аялалын тухай тэмдэглэлээ эмхтгэн “Францискийн лам нар Татарууд руу аялсан нь” (лат. *De Itinere Fratrum Minorum ad Tartaros*) нэртэйгээр бичиж үлдээсэн. Уг бүтээл польш, франц, англи зэрэг олон хэл дээр хэвлэгдсэний дотор монгол хэл дээр орчуулагдсан байна. Бенедикт Полакийн уг тэмдэглэлд Монголын Эзэн хааны Ромын Папад илгээсэн захидлын хуулбарыг оруулснаараа үнэтэй юм. Монгол, Польшийн харилцаанд хамаарал бүхий түүхэн энэхүү үйл явдлын дурсгалыг хүндэтгэн 2004, 2007 онд тус тус “Бенедикт Полакийн мөрөөр” аяллыг Варшав дахь манай ЭСЯ польш иргэдтэй хамтран зохион байгуулсан байдаг юм.

Хожим нь Монголд ирж байсан польшуудаас Антони Фердинанд Оссендовски “Хүн, араатан, бурхад” хэмээх бүтээлээрээ нэрд гарсан бөгөөд уг зохиол 1921 онд хэвлэлээс гармагцаа Европт ихэд алдаршиж дэлхийн 20 шахам хэлнээ орчуулагдан “К. Мэй болон Р. Киплингын зохиолуудтай энэ зэрэгцэх болсноор Барууны орнууд Монголыг сонирхоход түлхэц болсон гэж үздэг ажээ. Ф.Осендовски бол хятадын гамин цэргийг нийслэл хүрээнээс хөөн зайлуулж Богд хааныг ширээнд нь эргүүлэн залахад чухал үүрэг гүйцэтгэсэн гэлцдэг Барон Унгерны зөвлөх явсан хүн. Тэрээр Барон Унгерн олзлон дээрэмдсэн их хэмжээний алт эрдэнэсийн зүйлээ хаана нуусныг цухалзуулсан зүйл бичсэн тул энд тэндхийн олз хайж, аз хөөсөн доншуучид ч ихэд сонирхдог байсан гэх нь бий.

Монгол орон “капиталист бус хөгжлийн замаар” явж социализм байгуулах үйлсэд шамдаж байсан он жилүүдэд Европын социалист орнууд, түүний дотор тухайн үеийн БНПАУ манай гол түншүүд байж, эдийн засаг, техникийн болон мэргэжилтний тусламж дэмжлэг үзүүлж байсан билээ. Тэр үед хоёр орны улс төр, соёл боловсролын харилцаа сайн хөгжиж байсан төдийгүй Польшийн тусламжаар манай улсад барилгын материал, ой модны болон хөнгөн, хүнс, мал аж ахуйн үйлдвэрлэл хөгжүүлэхэд чухал үүрэгтэй Улаанбаатар, Чойбалсангийн хөнгөн бетоны завод, Дарханы царууц тоосго, шохойн үйлдвэр, Улаанбаатарын мод боловсруулах комбинат, нэхээсгүй даавууны үйлдвэр, халиман цавууны завод, Хархорины хаягдал боловсруулах үйлдвэр, дулааны цахилгаан станц болон орон нутагт мал эмнэлгийн лаборатори, оношлогооны кабинетууд зэрэг олон объект, аж ахуйн газрууд байгуулагдан амжилттай ажиллаж байсан юм.

Түүнчлэн социалист орнуудын хамтын ажиллагааны хүрээнд Монголд хэрэгжиж байсан Олон улсын геологийн экспедицийн ажилд Польш улс санхүү, техникийн туслалцаа үзүүлэхийн зэрэгцээ мэргэжилнүүдээ ирүүлэн идэвхтэй оролцуулж байв. Соёлын солилцоо амжилттай хэрэгжихийн зэрэгцээ Польшийн засгийн газрын тэтгэлгээр тодорхой тооны оюутан, аспирантуудыг



суралцуулах, мэргэжилтэй ажилчдыг дадлагажуулах талаар хамтран ажиллаж байснаас гадна шаардлагатай салбарт польш мэргэжилтнүүд Монголд ирж ажилладаг байжээ.

Хоёр орны худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаа өсөн нэмэгдэх чиглэлээр хөгжиж байсан бөгөөд 1957 онд худалдааны хэлэлцээр байгуулагдсанаас хойш монгол, польшийн хоорондын бараа эргэлт 1958 онд 1,7\* сая рубль\* байсан бол 1968 он гэхэд

6,5 сая\* орчим, 1973 онд 6,9 сая орчим рубль болтлоо өсч байжээ. Монголын тал арьс шир, ноос зэрэг гол төлөв малын гаралтай бүтээгдэхүүн, шевро, шеврет, арьсан ба савхин эдлэл зэрэг боловсруулсан бүтээгдэхүүн Польшид нийлүүлж, тэдний техник, эдийн засгийн тусламжтай байгуулагдсан үйлдвэрийн тоног төхөөрөмж, запас сэлбэг, хөдөө аж ахуйн зарим техник, АН-2 онгоц болон өргөн хэрэгцээний зарим бараа зэргийг Польшоос импортлож байв.

1990-ээд онд Монгол болон Польш улс ардчилал, зах зээлийн эдийн засгийн замыг сонгосон түүхийн шинэхэн үед шилжсэнээс хойш хоёр орны бүх салбарын харилцаа цоо шинэ үнэт зүйл, зарчимд тулгуурлан хөгжих боломж нээгдсэн билээ. Энэ үйл явцын тэргүүн эгнээнд Польшид сурч байсан болон сурч төгссөн залуус оролцож ардчилсан хөдөлгөөнийг эхлүүлэхэд идэвхийлэн зүтгэж явсан нь ч тус нөлөө үзүүлсэн биз ээ. Тухайлбал,

“1990 онд Монголын ардчилсан хүчний төлөөлөл Польш орныг зорьж Мазовше нутгийн Эв Санааны Нэгдлийн гишүүдтэй холбоо тогтоож байсан” гэх бөгөөд Монголын ардчилсан хүчнийхэнд туслах зорилгоор зурагт хуудас болон ухуулах бичгийн хэвлэх хэрэгслэл зэргийг Эв Санааны Нэгдлийн бэлэг болгон ирүүлж байжээ. Түүнчлэн анхны ардчилсан сонгуульд ажиглагчаа оролцуулах, ардчилсан Үндсэн хуулийг боловсруулах зэрэгт польшийн зүгээс бололцоотой дэмжлэг үзүүлж байсан болно.

1990-ээд оны сүүлчээс улс төрийн харилцаа төр, засгийн түвшинд идэвжиж харилцан хийсэн айлчлал, уулзалтуудын давтамж нэмэгдэн эрх зүйн орчин нь бэхжиж ирлээ. Тухайлбал, Ерөнхийлөгч Н.Багабанди 1999 онд, Ц.Элбэгдорж 2013 онд Польшид, Польшийн Ерөнхийлөгч Л.Качиньски 2008 онд, Б.Коморовски 2013 онд, Польшийн Ерөнхийлөгч асан, Эв санааны нэгдэлийн тэргүүн асан нэрт улс төрч Л.Валенца 2013 онд Монголд айлчилсан бөгөөд хоёр орны парламентын хамтын ажиллагаа идэвхитэй өрнөж УИХ-ын дарга 1997, 2015 онд, УИХ-ын төлөөлөгчид 8 удаа Польшид айлчилсан бол энэ хугацаанд Польшийн Сеймийн маршал 2 удаа, дэд маршал 4 удаа, польшийн парламентын төлөөлөгчид 5 удаа Монголд зочилжээ. Түүнчлэн хоёр орны парламентад хамтын ажиллагааг хөгжүүлэх парламентын бүлгүүд байгуулагдан идэвхтэй ажиллаж байна. Мөн Ерөнхийлөгчийн болон монгол, польшийн парламентуудын Тамгын газрууд ажил хэргийн айлчлал, уулзалтууд харилцан хийж ирэв.

Хоёр орны ГХЯ-ны шугамаар сайд, дэд сайд, ТНБД-ын зиндааны айлчлал, уулзалтууд амжилттай хэрэгжиж, улс төрийн зөвлөлдөх уулзалт, эдийн засгийн хамтын ажиллагааны хамтарсан комиссын хурал зэрэг бусад шугамаар хоёр талын болон олон улсын харилцааны сонирхсон асуудлуудаар тогтмол санал солилцож байна. Харилцааны эрх зүйн үндсийг шинэ үеийн нөхцөл байдалд нийцүүлэн зохицуулах талаар нэлээд зүйл хийгээд байгаа нь нийт харилцааны үндэс суурь, уур амьсгалыг зөв төлөвшүүлэн цаашид хөгжүүлэхэд зохих нөлөө үзүүлж байгаа юм.

Энхийг сахиулах олон улсын үйл ажиллагааны хүрээнд хамтран ажиллах явдал бидний хамтын ажиллагааны нэгэн чухал хэсэг болж байна. Иракт энхийг сахиулах ажиллагаанд Монгол Улс анх 2003 оноос Польштой хамтран ажиллаж эхэлсэн. Улмаар хоёр орны энэ салбарын харилцаа цаашид бэхжиж технологийн хамтын ажиллагаа хөгжүүлэх сонирхол нэмэгдэхийн хамт Польшийн цэргийн сургуульд монгол офицеруудыг суралцуулах, Польшид болдог батлан хамгаалах салбарын олон улсын үзэсгэлэнд монголын төлөөлөгчдийг урьж оролцуулах

зэрэг арга хэмжээ амжилттай хэрэгжиж байна.

Монгол. Польшийн худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд өсч нийт худалдааны эргэлт 2015 онд 39,8 сая ам.доллар байсан бол 2016 онд 41,2 сая, 2017 онд 48,5 сая, 2018 онд 58,3 сая, 2019 онд 64,9 сая гаруй ам. доллар болтлоо аажмаар нэмэгдсээр байгаа. Гэвч манай экспортын хэмжээ нэн бага байгаа бөгөөд хоёр орны худалдааны харилцааг тэнцвэржүүлэх, эрс идэвхжүүлэх шаардлагатай байгаа юм. Энэ үүднээс польшийн аж ахуйн нэгжүүд Монголд үйл ажиллагаа

явуулахад дэмжлэг үзүүлэх, улмаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх үүднээс хоёр орны Засгийн газруудын хооронд 33 жилийн хугацаатай, 0,15 хувийн хүүтэй, 50 сая еврогийн Нөхцөлт зээлийн хэлэлцээрийг 2017 оноос байгуулан хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ хүрээнд Гал түймэртэй тэмцэх тоног төхөөрөмжийг сайжруулах арга хэмжээнд зориулсан 9,5 сая еврогийн төсөл амжилттай хэрэгжиж эхлээд байна.

Худалдаа, хөрөнгө оруулалтыг цаашид өргөжүүлэх зорилгоор Польшийн хөрөнгө оруулалт, худалдааны Агентлагийн

төлөөлөгчийн газар Улаанбаатар хотноо нээгдэн үйл ажиллагаагаа явуулж эхлэв. Тус төлөөлөгчдийн газар МҮХАҮТ-тай хамтран 2019 онд Польш-Монголын бизнес форумыг амжилттай зохион байгуулсан бөгөөд уг арга хэмжээнд монголын 150 орчим бизнес эрхлэгчид, польшийн 20 гаруй томоохон компани, банкуудын төлөөлөл оролцсон байна. Ер нь польшийн компаниуд сэргээгдэх эрчим хүчний салбарт үлэмжхэн хөрөнгө оруулалт хийж технологую сайжруулж байгаа бөгөөд энэ хүрээнд Монгол улстай хамтран ажиллах, мөн дэд бүтэц, барилгын салбарт хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжих болон эм, эмийн үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарт, ялангуяа малын гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, стандартыг сайжруулан хөгжүүлэхэд хамтран ажиллах зэрэг ашиглаж болохуйц нөөц бололцоо бий гэж үздэг. Цаашилбал даяаршлын нөхцөлд дэлхий нийтийн глобал асуудлын нэг болж буй байгаль хамгаалах талаар гарч буй санал санаачлагыг хоёр тал анхааралтай судлаж хамтран ажиллах болон

**хүнсний тэргүүний техник технологийг хөгжүүлэх, уул уурхайн олборлох болон нүүрсийг цэвэршүүлэх технологи, эрчим хүчний үйлдвэрлэлийн шинэчлэл, эко технологийг нэвтрүүлэх асуудал ч хоёр талын хамтын ажиллагааны сонирхол татахуйц сэдэв байж болохоор байгаа юм.**

Түүнчлэн тээвэр, ложистикийн салбарт, ялангуяа Польшийг Европын төмөр замын сүлжээнд дамжин өнгөрөх гарц болгон ашиглах боломж ч нээгдэх цаг ойртсоор байна.

Монгол, Польшийн боловсрол, соёлын салбарын харилцаа бол хамгийн баялаг

уламжлалтай бөгөөд ирээдүйтэй хамтын ажиллагааны хэлбэр юм.

**Варшавын их сургуульд 60 гаруй жилийн өмнө Монгол судлалын тэнхим байгуулагдаад өнөөдрийг хүртэл тасралтгүй ажиллаж ирлээ. Варшав дахь монголын ЭСЯ болон Польш дахь монгол хэл, соёлын Төвийн дэргэд “Эрдмийн өргөө” монгол бага сургууль 2016 онд нээгдэн одоогоор 30 гаруй сурагчтай хичээллэж байна. Хамтын ажиллагааны нийт он жилүүдэд Польшид сурч, польш хэлийг сайн эзэмшсэн 5 мянга орчим монгол хүн байдгаас 800-1000 гаруй нь польшийн их, дээд сургуулийн төгсөгч нар. Эдүгээ польшийн тал жил бүр 25 монгол оюутан хүлээн авч тэтгэлэгт хөтөлбөртөө хамруулж байгаа бөгөөд 2019 оны байдлаар Польшид 190 шахам оутан, аспирант, докторант сурч байв. Эдгээр хүмүүс хоёр талын эдийн засгийн болон соёлын харилцааны гол түших тулгуур болж байдаг. Улмаар боловсролын салбарын цаашдын хөгжилд үнэтэй нэмэр оруулах Европын холбооны Erasmus+ зэрэг програмуудыг дэмжсэнээр Польш, Монголын энэ салбарын харилцаа тууштай хөгжих боломжтой юм.**

Манай улс 1959 оноос Варшав хотноо, Польш улс 1960 оноос Улаанбаатар хотноо тус тус ЭСЯ-аа нээн ажиллуулж ирсэн. Польшийн ЭСЯ нэг хэсэг “санхүүгийн боломжоос” шалтгаалан хаагдаж, эдүгээ Элчин сайд нь Варшав хотоос шууд ажиллаж байх хувилбарыг сонгон 2015 оноос хэрэгжүүлж байна. БНПАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд ноён Кшиштоф

Бойко 2019 оны 5 дугаар сарын 28-нд Итгэмжлэх жуух бичгээ барьсан бөгөөд Варшав хотноо ноён Бархасын Дорж 2020 оны 2 дугаар сараас Элчин сайдаар ажиллаж байна. Түүнчлэн албан ёсны дипломат харилцааг ардын дипломатын үйл ажиллагаагаар баяжуулан 2015 оноос Польш дахь Монголын Өргөмжит консул Ц.Уртнасан, 2011 оноос Монгол дахь Польшийн Өргөмжит консул Д.Ганхуяг нар хоёр талын хамтын ажиллагаанд зохих хувь нэмрээ оруулсаар байна.

Польшид эдүгээ 900 гаруй монгол иргэн байнга огшин сууж байгаа бөгөөд тэдгээрээс 600 орчим нь албан ёсоор хөдөлмөр эрхлэж байгаагийн дотор уламжлалт анагаах ухааны эмч нар олон жил амжилттай ажиллан хоёр орны иргэд хоорондын харилцааг өргөжүүлэхэд нааштай нөлөө үзүүлж байна. Монгол улсад Монгол-Польшийн найрамдлын нийгэмлэг, Польшид сургууль төгсөгчдийн холбоо ажилладаг бөгөөд Польшид бас Польш-Монголын найрамдлын нийгэмлэг, Польш дахь монголчуудын холбоо зэрэг байгууллагууд идэвхтэй ажиллаж байна.

Хоёр орны харилцаа цаашдаа Европын Холбоо-Монголын хамтын ажиллагааны хүрээнд ч улам бүр батжиж, манай “гуравдах хөршийн” бодлогын дагуу өргөжин хөгжих сайхан ирээдүйтэй юм. Энэ талаар Сеймийн дэд маршал хатагтай М.Гожевскагийн ” Би бол их өөдрөг хүн. Үүнээс үүдэн Монгол, Польш улсууд нь стратегийн түншүүд байх боломжтой гэдэгт итгэл дүүрэн байна.

Польш Улс Монгол Улсад Европын үүдийг нээж өгөөд, харин Монгол Улс Польш Улсад Азид хүрэх зам байх боломжтой” хэмээн хэлсэн үнэхээр өөдрөг үгээр энэхүү бяцхан өгүүллээ өндөрлөө.



**Х.Аюурзана**  
Элчин сайд асан, судлаач

## ЗҮҮН ХОЙД АЗИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА БА МОНГОЛ УЛСЫН ОРОЛЦОО

\*өмнөх дугаарт нийтлэгдсэн өгүүллийн үргэлжлэл.

Зүүн хойд Азийн орнуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх нь янз бүрийн талуудын ашиг сонирхолд нийцэх бөгөөд бүс нутгийн орнуудын нийтлэг хүсэл эрмэлзэл юм. ЗХА-ийн бүрэлдэхүүн орны хувьд Монгол Улс энх тайван, хөгжлийн үзэл баримтлалыг баримталж, эв найртай, найрсаг орчин бүрдүүлэхийн төлөө хүчин чармайлт гаргаж, бүс нутгийн улс орнуудын харилцаа холбоо, яриа хэлэлцээг ахиулахыг хичээдэг. Манай улс ЗХА-ийн бүх оронтой сайн, найрсаг харилцаатай бөгөөд хөрш зэргэлдээ улсуудтай газар нутгийн болоод бусад маргаангүй. НҮБ, АСЕМ, ШХАБ зэрэг олон талт механизмуудын үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог. Иймээс Улаанбаатар нь ЗХА-ийн бүс нутгийн аюулгүй байдлын болон бусад олон асуудлаар яриа хэлэлцээ явуулах нэгэн төв болж чадах үндэстэй юм.

Монгол Улс 1980-аад оны эхээр бүс нутгийн аюулгүй байдлын яриа хэлэлцээний механизм байгуулах санааг анх дэвшүүлж байсан. Харин хэдэн жилийн өмнөөс буюу 2014 оноос эхлэн ЗХА-ийн аюулгүй байдлын асуудлаарх Улаанбаатарын яриа хэлцээг (UBD) зохион байгуулж эхлээд байгаа. Энэ хүрээнд жил бүр олон улсын бага хурал хийж, уг хуралд төр засгийн албаны хүмүүс, эрдэмтэн судлаачид оролцдог бөгөөд бүс нутгийн аюулгүй байдлын зэрэгцээ эрчим хүч, дэд бүтцийн сүлжээ, ногоон хөгжил, хүмүүнлэгийн хамтын ажиллагаа зэрэг олон асуудлыг хэлэлцэж байна. Ялангуяа сүүлийн жилүүдэд албаны хүмүүс тус хуралд оролцох болсон нь

түүний нэр хүнд, ач холбогдлыг улам нэмэгдүүлж байна.

Монгол Улс тус бүс нутгийн эдийн засгийн интеграцлал, дэд бүтцийг хөгжүүлэх, эрчим хүчний нөөцийг ашиглах, байгаль орчныг хамгаалах, үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэхэд хамтран ажиллах чиглэлийг тууштай баримталдаг. Манай улсаас тус бүс нутгийн орнуудтай хийж буй худалдаа жил бүр өсөн нэмэгдэж байна.

Жишээлбэл, Монгол, Японы эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрт (ЕРА) 2015 оны 2 дугаар сарын 10-нд Токио хотноо гарын үсэг зурсан бөгөөд 2016 оны 6 дугаар сарын 7-нд хүчин төгөлдөр болсон. Энэ бол Монгол Улсын хувьд анхны эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр бөгөөд энэхүү хэлэлцээр нь Монгол, Японы “стратегийн түншлэл”-ийн харилцааг бэхжүүлэхэд чухал хувь нэмэр оруулна гэж үзэж байна. Уг хэлэлцээрийн дагуу Монгол Улс 97 бүлгийн 5700 орчим барааны гаалийн татварыг цуцлах буюу бууруулах бөгөөд Япон улс 97 бүлгийн 9300 нэр төрлийн барааны гаалийн татварыг цуцлах буюу бууруулах юм.

БНСУ-тай эдийн засгийн түншлэлийн гэрээ байгуулах хамтарсан судалгааны ажил эдүгээ ид өрнөж байна. Мөн Монгол Улс Евразийн эдийн засгийн холбооны орнуудтай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулахаар ярилцаж байгаа бөгөөд Хятад улстай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах

асуудлыг мөн хамтран судалж байна.

Монгол Улс ЗХА-ийн эдийн засгийн интеграцийн үйл явцад үр ашигтай оролцох боломжтой юм. Манай улс нүүрс, үнэт метал, эрчим хүчний асар их нөөцтэй. Тиймээс ашигт малтмал олборлох, боловсруулах, ашиглах чиглэлээр хамтран ажиллах боломжтой. Манай улсын хувьд энэ чиглэлээр хамтран ажиллахад гадаадын хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа билээ. Тэгвэл Хятад, Япон, Өмнөд Солонгос нь энэ чиглэлээр манай улстай хамтран ажиллах илүү боломж, санхүүгийн эх үүсвэр, технологитой байна.

Хятадын засгийн газраас хэрэгжүүлж буй “Нэг бүс, нэг зам” бодлого нь тус бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд маш таатай боломж олгож байна. Иймээс манай улс Хятадын “Нэг бүс, нэг зам” санаачилгыг өөрийн дэвшүүлсэн “Хөгжлийн зам”-ын бодлоготой уялдуулан хэрэгжүүлэхээр санаачилга, хүчин чармайлт гарган ажиллаж байна.

Мөн Монгол, Орос, Хятад гурван улс эдийн засгийн коридор байгуулах тухай санамж бичигт 2015 онд гарын үсэг зурсан. Энэхүү хөтөлбөр нь гарын үсэг зурсан өдрөөс хойш таван жилийн хугацаанд хүчинтэй бөгөөд цаашид тав таван жилээр сунгагдан хэрэгжих юм. Уг хөтөлбөрийн хүрээнд талууд дэд бүтэц (төмөр зам, авто зам, эрчим хүчний сүлжээг шинэчлэх), аж үйлдвэр, байгаль орчин, шинжлэх ухаан, хөдөө аж

ахуй, хүмүүнлэгийн чиглэлээр 32 төслийг хэрэгжүүлэхээр тохиролцоод байна.

ОХУ-ын Дорнын эдийн засгийн чуулганы үеэр Монгол, Оросын Ерөнхийлөгчид Монголоор дамжуулан Хятадруу байгалийн хий дамжуулах хоолой барих асуудлаар тохиролцсон бөгөөд саяхан ОХУ-ын Ерөнхийлөгч уг төслийг эхлүүлэх үүргийг ОХУ-ын “Газпром” нээлттэй хувьцаат нийгэмлэгт өгсөн байна. “Сибирийн хүч-2” гэсэн энэхүү хийн хоолойгоор жилд 50 тэрбум куб.метр байгалийн хий дамжуулах боломжтой гэсэн урьдчилсан судалгаа гарсан бөгөөд уг төсөл нь гурван улсын төдийгүй ЗХА-ийн бүс нутгийн хамгийн том төслүүдийн нэг болох юм. Монгол улс энэхүү төсөлд ихээхэн ач холбогдол өгч шадар сайдаар ахлуулсан ажлын хэсгийг байгуулаад байна.

ЗХА-ийн хамгийн тулгамдсан асуудал бол эрчим хүчний хангамж юм. Газрын тос, байгалийн хийгээс гадна сэргээгдэх эрчим хүч нь эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой билээ. Сүүлийн жилүүдэд сэргээгдэх эрчим хүчний салбар, ялангуяа нар, салхины эрчим хүчийг ашиглах явдал өргөн дэлгэрч байна. Жишээлбэл, 2017 онд дэлхийд шинээр сууриллуулсан цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн хүчин чадлын 70 хувь нь сэргээгдэх хүчний эх үүсвэр байна. Өнөөдөр дэлхий даяар сэргээгдэх эрчим хүчнээс гаргаж буй эрчим хүчний үйлдвэрлэл 2195 гигабитт хүрч, дэлхийн эрчим хүчний хэрэглээний 18,2 хувийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс хангаж байна.

Монгол Улс сэргээгдэх эрчим хүчний асар их нөөцтэй. Олон улсын сэргээгдэх эрчим хүчний агентлаг (IRENA) Монгол Улсын Эрчим хүчний яамтай хамтран Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний нөөц

боломжийн талаар судалгаа хийж тайлангаа танилцуулсан байна. Энэхүү судалгаанаас үзвэл манай улс нар, салхины эрчим хүчийг ашиглан жилд 15 мянган тераватт / цаг (15000000 МВт цаг) цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх боломжтой ажээ. Тиймээс Монгол Улсын Ерөнхийлөгч “Зүүн хойд Азийн эрчим хүчний сүлжээ” байгуулах санал дэвшүүлээд байна. Энэ нь Япон, Өмнөд Солонгосын дэвшүүлсэн “Азийн супер сүлжээ” төсөлтэй уялдан хэрэгжих боломжтой юм. Энэхүү саналыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Зүүн хойд Азийн эрчим хүчний сүлжээ ба хамтын ажиллагаа” гэсэн форумыг 2018 онд Улаанбаатар хотноо зохион байгуулсан билээ.

Түүнчлэн Хятад, Өмнөд Солонгос, Хойд Солонгос, Орос, Японы төлөөлөгчдийн оролцоотойгоор “Зүүн Хойд Азийн бүс нутгийн эрчим хүчний сүлжээний стратеги” сэдэвт уулзалтыг 2019 оны нэгдүгээр сард Улаанбаатар хотод зохион байгуулсан. Энэхүү уулзалтын зорилго нь эдгээр улсуудыг холбосон эрчим хүч дамжуулах шугам байгуулах боломжийг судлахад чиглэсэн юм.

ЗХА-ийн орнууд цахилгаан дамжуулах шугам, байгалийн хийн хоолой барих, нүүрсний худалдаа хийх зэрэг олон төслийг хамтран хэрэгжүүлэх сонирхолтой байна.

Энэ нь эрчим хүчний нөөцгүй бүс нутгийн орнуудыг эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангахад чухал ач холбогдолтой юм.


Монгол Улс нүүрс, түүний дотор коксжих нүүрс ихтэй учраас коксжсон нүүрсийг Орос, Хятадын далайн боомтоор дамжуулан Япон, Өмнөд Солонгос руу экспортлох бодлого баримталдаг. Энэ зорилгоор гол коксжих нүүрсний ордоос далайн боомт руу нүүрс хүргэх зорилгоор төмөр зам барьж байна.

ЗХА-ийн эрчим хүчний хэрэглээ 2040 он гэхэд бараг хоёр дахин нэмэгдэх төлөвтэй байна гэж олон улсын байгууллагууд тооцоолжээ. Хэрэв Монгол улс өөрийн нөөц боломжийг зөв ашиглаж чадвал бүс нутгийн зах зээлд эрчим хүчний гол нийлүүлэгч болж чадах юм. Ерөнхийд нь дүгнэн хэлэхэд Монгол Улс бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаанд илүү идэвхтэй, үр дүнтэй оролцох бодит боломж байна.

Дэлхийн улс төр, эдийн засгийн байдал таатай бүс байгаа ч ЗХА-ийн байдал ерөнхийдөө тогтвортой байна. Бүс нутгийн орнууд энэхүү түүхэн ховор боломжийг ашиглан хамтын ажиллагаагаа улам хөгжүүлж, хамтдаа бүс нутгийнхаа энх тайван, тогтвортой байдал, хөгжил цэцэглэлтэд идэвхтэй хувь нэмэр оруулах болно.

### Азийн супер сүлжээ (The Asian Super Grid)





**Alex Berezow**

Geopolitical futures-ийн шинжээч

# FOUR CORONAVIRUS LESSONS THAT WE WILL (OR WON'T) LEARN\*

**W**hen a patient dies in a hospital, it's not uncommon for doctors to convene what is known as a morbidity and mortality conference, the goal of which is to determine what went wrong and why. In the months and years following a national crisis, we engage in a somewhat similar process. Over time, official investigations are carried out, and political leaders, the media and the public initiate ad hoc debates meant to arrive at a general understanding of the primary cause of the crisis and what steps need to be taken to prevent something like it from ever happening again.

After 9/11, we learned that the American homeland was vulnerable to direct attack by actors from the Middle East. After the Great Recession of 2008, we learned that mortgage-backed securities are not automatic moneymakers and that subprime mortgages are a potential disaster-in-waiting if real estate values don't go up. Similarly, the COVID-19 pandemic will offer several lessons.

**1**

## Lesson #1

*There is an optimal balance in response to a pandemic that is somewhere between the two extremes of “total lockdown” and “totally open society.”*

The most important question is: Were lockdowns necessary to stop the spread of the coronavirus? From a scientific perspective, this is unanswerable because there were no consistent control (i.e., no lockdown) and experimental (i.e., total lockdown) groups. There was no alternative universe in which we didn't implement lockdowns to compare to our own.

Largely for domestic political reasons, both sides of the debate will claim to have been correct. Those believing the worst-case scenario COVID-19 models that predicted hundreds of thousands or millions of American deaths will say that lockdowns and extreme social distancing prevented a complete catastrophe. Those who do not believe the worst-case scenar-

io was inevitable without a lockdown will claim that the models were exaggerated or, at the very least, that the ends did not justify the means.

From a scientific approach, the only conceivable way to resolve this dispute will be to rely on yet more models – the very same models whose validity is under question. Beyond the sophisticated speculation provided by models, science tells us that we can never have a certain answer to the most important question raised by the pandemic. From a geopolitical standpoint, this poses a substantial problem. Governments will want to know how to act the next time a pandemic occurs, and the public could get angry if it perceives that no lessons were learned.

## 2

## Lesson #2:

*Putting the recommendations of scientists, public health officials and academics into practice often clashes with other geopolitical realities.*

Whenever there is a crisis, there is a strong tendency to turn toward experts or technocrats for solutions. The trouble with experts is that they often struggle to place their important work into a bigger picture. In this case, those favoring harsh lockdowns claimed to be “following the science.” Indeed, *one scientist from Imperial College said* that the U.K. would need to maintain “a significant level of social distancing, probably indefinitely until we have a vaccine available.” While such a statement may be scientifically sound, it is not feasible since it fails to incorporate the realities of everyday life. Another problem is that “the science” does not provide unambiguous guidance. For instance, there is good reason to believe that there may never be a particularly effective vaccine against COVID-19. The reason is fundamentally biological: Coronaviruses might not induce lifelong immunity in humans.

Additionally, there are other factors than science involved in a government’s response to a pandemic, such as legal, ethical and economic considerations. Allowing any one factor to dominate policymaking can produce an undesirable outcome. The COVID-19 pandemic morphed into a major geopolitical event and, therefore, the tools of geopolitical analysis became ever more relevant. That is likely why Winston Churchill famously said, “Scientists should be on tap, but not on top.” Rightly or wrongly, in this case, many in the public will perceive that the science factor was prioritized, to such an extent that economic health was subordinated to public health. Therefore, the scientific community, like politicians, will be held accountable for their actions and recommendations. Almost inevitably, this will *erode public faith in the medical establishment.*

## 3

## Lesson #3:

*The general public must face the price of life-or-death trade-offs.*

When government officials evaluate the pros and cons of their proposed actions, they often do so through the lens of opportunity cost. Resources are not unlimited, and each action comes at a cost. Often, the best way to measure these costs is to first convert whatever is being measured – time, productivity, opportunities – into dollars and cents. This can even be done with human health and life itself.

Many people say that one cannot put a price tag on human life. This is true from a moral or philosophical perspective. In the eyes of God, all of us are equal and intrinsically invaluable. (Even atheists are unlikely to question that conclusion, though they obviously don’t agree that God is the source of our intrinsic value.) In the eyes of an economist, however, we are neither equal nor invaluable. How does one begin to put a price tag

on a human life? A simple thought experiment demonstrates how easy it is. Pretend that you’re the mayor of a small town. There’s a dangerous intersection that results in one car crash fatality every year. A company approaches you with a solution: By redesigning and rebuilding the intersection, it can guarantee no more car crashes. The only problem is that the infrastructure project costs \$100 million. Considering that your small town’s budget is far less than that, the city couldn’t afford it without a massive tax increase. You propose that tax increase to your citizens, who reject it overwhelmingly. The citizens have spoken: The lives of those who will be killed in accidents at the intersection are not worth \$100 million.

Even though we don’t like to admit it, we make personal decisions like this all the time. A family would

likely spend itself into bankruptcy to save the life of a child but not the life of their 95-year-old grandfather. Why? Because we know that a child potentially has a long, bright and prosperous future ahead of her, but grandpa does not. Life insurance companies make calculations like this on a daily basis. (A website run by the non-profit organization Life Happens features a *human life value calculator* that determines how much your life is worth to your family, strictly in financial terms.) For what it's worth, various U.S. government agencies value a life *between \$9 million and \$10 million*.

The key is to remember that we are talking about economic value rather than moral value. There is always space for a moral consideration in geo-

politics, but it too must be considered along with other factors. This must be kept in mind in regard to the coming debate over whether the COVID-19 lockdown was worth it. One way that society is wrestling with that question is by comparing the costs of the lockdown (e.g., the decrease in gross domestic product) to its benefits (e.g., the economic value of the lives saved). Simultaneously, we must also consider that the lockdown itself may be directly or indirectly *responsible for excess deaths* due to suicide or cardiovascular events, cancer and other causes, some of which may be due to fear of going to the hospital. While governments have regularly confronted these dilemmas when pondering military action, doing so from a public health perspective was in many ways uncharted territory.

## 4

## Lesson #4:

*The global supply chain requires redundancies because interdependence is not enough.*

Of all the lessons on offer from COVID-19, this one is the most obvious. Over the past few months, we learned that a domino effect, beginning with the halting of China's economy, can trigger logistical nightmares that can collapse supply chains and ruin economies. Nations also received a wake-up call on just how much they depend on foreign countries for products vitally important to their populations' well-being. Even products that are a national security interest, such as pharmaceuticals and medical devices, are at least partially manufactured abroad. Finally, we learned that our allies will hoard resources in a crisis. Italy, in particular, learned that lesson the hard way about the EU.

There will be tremendous pressure on governments to create national stockpiles of vital materials, create redundancies in their supply chains

and be more self-sufficient wherever possible. That could require onshoring some manufacturing capabilities that are deemed vital to the national interest. If that proves too impractical or economically inefficient, another possibility would be to create global supply chain alliances between trusted countries. Of course, any such alliance must be constructed in a way that precludes the fiasco that briefly played out in the EU. Thus, as countries and multinational corporations prioritize self-reliance after COVID-19, they will look to increase their production capacity for crucial supplies and medicine and will be more selective in building trade affiliations with the countries they trust the most. In other words, supply chains increasingly will be based on security and resilience.

May 1, 2020

\* *Geopolitical futures*-ийн шинжээч А.Березовын нээлттэй өгүүлэл <https://geopoliticalfutures.com/author/aberezow>

# ҮЙЛ ЯВДЛЫН ХЭЛХЭЭС

2020 ОН

03 САР

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга шинэ коронавирус хурдацтай тархаж буйн улмаас олон хүний амь нас эрсдэж байгаад сэтгэл зовниж буйгаа илэрхийлж Европын 14 улсын төрийн тэргүүнд 2020 оны 3 дугаар сард захидал илгээв.

03.02

Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга М.Помпеотой 2020 оны 3 дугаар сарын 2-ны өдөр утсаар ярьж, хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.

04.02

УИХ-ын дарга Г.Занданшатар АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд М.Клеческийг 2020 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр хүлээн авч уулзан, цаг үеийн асуудлаар санал, мэдээлэл солилцов.

04.15

АНЭУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд баригдах Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 25 дугаар цэцэрлэгийнн шинэ барилгын шав тавих ёслолын ажиллагаа 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр болов.

04.27

Монгол Улс, Бүгд Найрамдах Чех Улс хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойг тохиолдуулан Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар Чех Улсын Элчин сайд И.Бродскийг 4 дүгээр сарын 27-ны өдөр хүлээн авч уулзаж, дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойн хүрээнд тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний талаар санал солилцов.

04.29

Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан тэргүүтэй ГХЯ, ХХААХҮЯ-ны газар, нэгжийн удирдлага 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр ГХЯ дээр уулзалт хийж, хоёр яамны үйл ажиллагааны уялдааг сайжруулах талаар ярилцлаа. Хоёр яамны удирдлага дэлхий нийтийг хамарсан ковид-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэл, түүний дотор гадаад худалдаанд тулгарч буй сорилт бэрхшээлийг даван туулах, уул уурхайн бус экспортын хэмжээг хүрсэн түвшингээс бууруулахгүй байх боломж, энэ чиглэлд цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцов. Хоёр сайд “ГХЯ, ХХААХЯ-наас ковид-19 цар тахлын нөхцөл байдалд экспортыг дэмжих, импортыг тогтвортой байлгах чиглэлээр хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд гарын үсэг зурж, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд яамдын газар, нэгж, хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газруудын үйл ажиллагааг чиглүүлж ажиллахаар тохиров.

04.30

“Биокомбинат” УТҮГ-ыг шинэчлэх төслийн хүрээнд Монгол Улсын Сангийн яам болон Унгар Улсын Экспорт-Импорт банк хоорондын зээлийн хэлэлцээрт 4 дүгээр сарын 30-ны өдөр Будапешт хотноо гарын үсэг зурав.